

О.Чимэг

МУИС-ийн Шашин судлалын
тэнхимийн багш

ЗОНХАВАГИЙН “БОДЬ МӨРИЙН ЗЭРЭГ” ДЭХ НИЙГМИЙН ФИЛОСОФИЙН ҮЗЭЛ САНАА

Товч утга: Гэлүгва ёс нь Төвдөд төдийгүй Монгол орноо өргөн дэлгэрсэн шашны чиглэл бөгөөд нэлээд хэдэн зууны уламжлалтай учраас эдгээр орнуудын нийгмийн амьдралд ихээхэн нөлөө үзүүлсэн, одоо ч үзүүлсээр байна. Тус чиглэлийн онолын үндэс нь түүний үндэслэгч Богд Зонхавагийн “Бодь мөрийн зэрэг” зохиол юм. Энд тус зохиолын үзэл санааг нийгмийн философийн талаас нь авч үзэж байгаа юм.

Гэлүгва ёсны нийгмийн философийн тулгуур үндэс нь гурван төрөлхтөний тухай сургаал хэмээн үзэж, эдгээрийг ялгах нэг гол шалгуур болох бясалгалын талаархи Зонхавагийн сургаалыг “нийт хүнд байдаг сэтгэн бодох үйл ажиллагаа” хэмээн тайлбарлав. Эцэст нь гэлүгва ёсны нийгмийн философийн тулгуур зарчим, теократи засаглалын онолын үндэс хэмээн авч үзсэн багшийг шүтэх ёсыг тайлбарлахад өгүүллийн ихээхэн хэсгийг зориулсан болно. Зохиогчийн үзэж байгаагаар бол, Зонхавагийн онолын хувьд үндэслэсэн багшийг шүтэх ёс нь багшийн үзэл санааг даган баримталж, түүнд үнэнч байхыг номлосноороо намч зарчмын тусгал болсон бөгөөд гэлүгва ёсны сүм хийдийн зохион байгуулалтад бодитойгоор биелсэн байна.

Түлхүүр үг: buddhism, theoretical state, meditation, three categories of people, gelukpa, the teacher's worship.

Хүн төрөлхтний эцсийн зорилгын тухай асуудлыг шийдвэрлэх оролдлогууд эцэс төгсгөлгүй учир үнэмлэхүй үнэнд хүрэх эрмэлзэл бүхий онолууд ямар нэгэн эцсийн дүгнэлт хийж, амьдрал практикт нэвтрэх болж, нийгмийн бүхий л харилцаанд нөлөөлж иржээ. Энэ үйл явцад тухайн үзэл санааг баримтлагчид зохион байгуулалтад орсноор асар их нэгтгэгч хүч төдийгүй салган тусгаарлах хүч болж иржээ. Тэдний баримталж буй онол, сургаалууд үндэстэн, бүс нутгийн үзэл суртал, шашин болтлоо хөгжиж, олон янзын эрх ашигт үйлчилж ирсэн бөгөөд нэлээд тохиолдолд үндсэрхэх үзлийн элдэв илрэлтэй ч холбоотой болж байсан байна. Дэлхийн улс орнуудын харилцан нөлөөлөл ихсэж, харилцан ойлголцохыг бэхжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа өнөөгийн нөхцөлд нийгэм улс төрийн сургаалын үүрэг гүйцэтгэж ирсэн шашин, философийн тулгуур сурвалжуудыг судалж, нийгмийн сэтгэлгээнд гүйцэтгэж ирсэн

үүрэг, практик ач холбогдлыг нь тодорхойлох явдал нэлээд чухал юм.

Эдгээр сурвалжуудын тоонд Төв Азийн нэлээд улс үндэстний хувь заяанд чухал үүрэг гүйцэтгэсэн буддын шашны нэрт төлөөлөгч, "шинэтгэгч" хэмээн алдаршсан ХIY-XY зууны философич Зонхавагийн "Бодь мөрийн зэрэг" зохиол зүй ёсоор орно.

Шашнаар зогсохгүй тухайн үеийн Төвдийн нийгмийг шинэчлэх үүрэг гүйцэтгэж, бүс нутгийн улс төрийн харилцаанд ч нөлөө үзүүлсэн гэлүгва чиглэлийн онолын үндэс нь Богд Зонхавагийн "Бодь мөрийн зэрэг" зохиол юм. Энэ зохиолын үзэл санааг нийгмийн гадаад, дотоод нөхцөлтэй нь холбон авч үзэх явдал нийгэм-улс төрийн бусад сургаалуудын дотор эзлэх байр суурийг нь тодорхойлох бололцоо олгох юм.

Богд Зонхавагийн үзэл санаа Монголын нийгмийн амьдралд олон жилийн уламжлалтай учраас түүнийг судлах нь манай ард түмний "уламжлалт сэтгэлгээг" ойлгоход тус дөхөм болох онолын төдийгүй, мөн практик ач холбогдолтой болно.

"Бодь мөрийн зэрэг" гэлүгва ёсны нийгмийн философийн
онолын үндэс болох нь

Аливаа шашин тухайн улс орны нийгмийн сэтгэлгээнд гүн гүнзгий ул мөрөө үлдээж, амьдралын бүхий л хэв загварыг тодорхойлогч хүчин зүйлүүдийн нэг нь болдог. Нийгмийн олон үзэгдлийн үндэс шашнуудад тавигдсан гэж үзэх үндэстэй бөгөөд энд нийт нийгмийг чиглүүлэх үзэл суртал болсон намын тухай сургаалыг нэрлэж болох юм.

Томоохон шашнууд олон зуун жилийн туршид амьдралын философийг номлож ирэхдээ хүний сэтгэлд нөлөөлөх арвин туршлага хуримтлуулсан төдийгүй тухайн үеийн нийгмийн эрэлт хэрэгцээг тусган боловсорсоор иржээ. Нийгмийн цаашдын хувь заяанд үзүүлсэн нөлөө нь шашны томоохон зүтгэлтнүүдийн түүхэнд эзлэх байр суурийг тодорхойлох хэмжүүр гэж үзэх юм бол богд Зонхава нь буддын шашны түүхэнд онцгой байр суурь эзлэх сэтгэгч төдийгүй шарын шашин дэлгэрсэн улс орнуудын нийгмийн байгуулалд ч хүчтэй нөлөө үзүүлсэн хүн юм.

Зонхава "Бодь мөрийн зэрэг" зохиолдоо лам, хар аль ч хүн гэгээрч, бурхан болох мөрийн дэс дарааг оюун санаанд нь тохируулан зааж, зохиолоо оюун судлалын ном гэж үзсэн байдаг.

Их хөлгөний философи онолыг үндэслэгч Нагаржуна, Асанга нарын гүн үзэл, аугаа их явдал буюу Их хөлгөний онол, практикийг нэгтгэсэн мөрийн зэргийн зохиолууд нь амьдралын эрхэм зорилго болсон бурхан болж гэгээрэх, түүний дагуу аж төрөх зам мөрийг үзэл, явдал, бясалгал гурвын цогцоор авч үзсэн амьдралын философийг агуулдаг. Мөрийн зэргийн эдгээр зохиолууд төвдийн буддын философийн онцлог болж хөгжжээ.

Х зууны үеийн нэрт сэтгэгч Атишагийн "Бодь мөрийн зул" зохиолд тусгалаа олсон гурван төрөлхтний тухай энэхүү үзэл санаа гэлүгва ёсыг үндэслэсэн богд Зонхавагийн "Бодь мөрийн зэрэгт" төвдийн нийгмийн үзэл суртлын тулгуур болтлоо хөгжжээ.

Нийгмийн бүхий л амьдралын философи болж хувирсан энэхүү сургаалын эцсийн зорилго нь нийгмийн нийт гишүүдийг бурхан болох зам мөрөөр хөтлөх явдал байсан учраас энэ зорилгыг бүх нийтийн гэгээрэл гэж томъёолж болох юм. Гэгээрч танин мэдэхүйн энэ асуудал үнэмлэхүй үнэн хэмээх туйлын чанартай холбогдож тавигдсан байна.

Гэхдээ богд Зонхава нийт төрөлхтний өмнө энэ зорилгыг тавихдаа эн тэргүүнд ертөнцийн тусыг бодох нь зүйтэй хэмээн үзсэн байдаг.

Нийт бодгалийг гурван төрөлхтөн болгон хувааж, хүмүүсийг энэ замаар хөтлөх арга замыг заасан тус номлол Төвдийн нийгмийг бурханы шашны үзэл санааны дагуу зохион байгуулах тулгуур үндэс болсон юм. Эл зохион байгуулалт багшийг шүтэх ёсон дээр тогтох ёстой байсан бөгөөд богд Зонхавагийн өөрийн нь төлөвшүүлсэн сүм хийдийн зохион байгуулалт энэ нийгмийн загвар болсон байна.

Ийнхүү бурхан болж гэгээрэх зорилгоор нэгдэж, бусдыг энэ замаараа хөтлөх үлгэр дууриал болсон хуврагийн нийгэмлэгүүд эртний Энэтхэгт байсан боловч нийт нийгмийг хамарч чадаагүй бол богд Зонхавагийн "Бодь мөрийн зэрэг" зохиолд үндэслэн боловсруулсан нэг зам мөрийн тухай болон энэ мөрөөр хөтлөх багшийг шүтэх ёсны тухай үзэл санаа Их хөлгөний номлолыг нийгмийн хэмжээнд нэвтрүүлэх онолын үндэс болж, амтдралд бодит биеллээ олсон юм.

Үзэл санааг нийгмийн байгууллын тулгуур үндэс гэж үзэх юм бол богд Зонхаваг буддын ёсны нийгмийн байгууллын үндэс суурийг тавьсан хүн гэж үзэж бүрэн болно.

Бурханы шашинд хойд настай холбоотойгоор үндэслэн тавьсан "төгс ахуйн" тухай сургаал богд Зонхавагийн номлолоор нийт хүн төрөлхтнийг чиглүүлэх нэг зам мөрийн тухай сургаал болон боловсорч, түүнд хүрэхийг эрмэлзэж, бусдыг энэ замаар хөтлөгч бодьсатвагийн тухай сургаал "багшийг шүтэх ёс" болон боловсорч, "намын зохион байгуулалтын" анхдагч хэлбэрийн нэг байсан хуврагийн нийгэмлэг богд Зонхавагийн үйл ажиллагаагаар нарийн чанд зохион байгуулалтаа олж, нэг хүнийг тахин шүтэх ёсны төгс илрэл болох теократи засаглалд хүргэжээ.

Энэ утгаар шарын шашныг католик шашинтай харьцуулж болох юм. Энэ хоёр шашинд туйлын санаа ба түүнд тэмүүлэгч нийгэм практик биеллээ олсон анхдагчууд гэж үзэж болно.

Тийм учраас хэдийгээр богд Зонхава анхан үеийн бурханы шашны үзэл санааг хэрэгжүүлэхийг зорьж үйл ажиллагааныхаа удирдлага болгож байсан боловч түүнийг шинэчлэгч гэж үзэх нь үндэстэй юм. Ерөөс нийгмийн нөхцөл байдлаа даган хөгжиж байх нь

нөөц бололцоогоо шавхаагүй үзэл санааны үзүүлэлт мөн бөгөөд тэрхүү үзэл санааг үеэ өнгөрөөлгүй "шинэ" байлгахад оруулсан хувь нэмэр нийгмийн зүтгэлтний цар хүрээг илтгэх бус уу.

Богд Зонхавагийн шинэчлэлийг товчид нь нэг зам мөрийн тухай сургаал ба багшийг шүтэх ёсыг онолын хэмжээнд гарган тавьснаар тодорхойлж болох юм.

Богд Зонхава бясалгалын тухай

Богд Зонхавагийн номлосон багшийг шүтэх ёсонд тулгуурлаж дороос дээш дэвшин дэвжих зорилгын хэрэгжилт нь ам авснаар бус, харин биелж хүрсэн бодит түвшин, хийж бүтээснээр хэмжигдэх ёстой байв. Гэхдээ бодит амьдрал дээр энэхүү "түвшин" ба "хийж бүтээснийг" үнэлэх шалгуур нэлээд тохиолдолд "албан тушаалын зэрэглэл" болж хувирсан гэж үзэж болох юм.

Хийж бүтээнэ гэдэгт "Бодь мөрийн зэрэгийн" үзэл санаагаар шашны үзэл санааг амьдрал практик дээр хэрэгжүүлэхийг ойлгох юм. Үүний тулд сургаал номлолыг нь танин мэдэж, ажил явдлаараа хэрэгжүүлэх төдийгүй, бодит амьдралтай жишиж ухаарах чадвар хэрэгтэй.

Тийм ч учраас "Бодь мөрийн зэрэгт" бясалгалын эрдмийг багтаасан амарлин оршихуй ба үлэмж үзэхүйн тухай сургаал чухал байр суурийг эзэлдэг.

Дияан бясалгал бол угтаа нийт хүнд байдаг сэтгэн бодох үйл ажиллагаа, амьдралын үзэгдлийг оюун ухаандаа бодож шинжлэх процесс юм. Амарлин оршихуй ба үлэмж үзэхүйн тухай сургаалд энэ үйл ажиллагаа явагдах арга, эрэмбэ дарааг харуулсан байна.

Гэхдээ энэ үйл ажиллагаа бурхан болж гэгээрэхэд өөрийгөө зориулсан хүмүүс буюу лам хуврагуудад юуны өмнө хамаатай байсан учраас түүнд саад болох бусад үйлдэл, тухайлбал арилжаа наймаа зэрэг прагматик салбаруудаас хөндий байхыг бясалгал хэрэгжүүлэх нэг чухал нөхцөл болгон тавьсан байна.

Нөгөөтэйгүүр, энэхүү сэтгэн бодох үйл ажиллагаа эн тэргүүнд буддын философийн сургаал номлолыг ухаарч эзэмшихэд зориулагдаж байсанд дияан бясалгалын талаархи буддын сэтгэлгээ, үзэл санааны онцлог тал оршино.

Урьдын сэтгэгчдийн сургаал номлолыг сонсож, цээжилж, тогтосноор бус, харин энэхүү сургаал номлолын үзэл санааг бодит амьдралаар туулж, оюун ухаандаа өөрийн болтол, "хувийн туршлага" болтол бодож шинжилсний үндсэн дээр эзэмшиж байж, юу хэлэх гэснийг нь ойлгох бололцоотой болно гэсэн дүгнэлтийг "Бодь мөрийн зэрэгийн" үзэл санаанаас хийж болох юм.

Амьдралаар туулж олсон энэхүү туршлагаа бусдын хүртээл болгох нь угтаа багш хүний үйл ажиллагааны мөн чанар билээ. Ийнхүү бусдын тусыг бодож сансар хорвоогийн үйл хэрэгт оролцож байдаг бодьсатвагийн тухай үзэл санаа багшийг шүтэх ёс болж

төлөвшсөн нь бурханы шашны үзэл санааны хөгжлийн үр дүн болон гарч ирж байгаа юм.

Үнэмлэхүй үнэнд хүрэх бясалгалын эцсийн үр дүн бол бурхан болохуй болно. Их хөлгөнд “туулсан бурхан бодь сэтгэлээс” төрнө хэмээн үздэг нь бодит гэгээрэл бол хамаг амьтны тусыг бүтээх амьдралын туршлагаас төрнө гэсэн үг юм. Бусдын тусыг бүтээх нь зовлонгоос ангижруулах зорилготой бурханы шашны зам мөрөөр хамаг амьтныг хөтлөх явдал бөгөөд энэ нь бодьсадвагийн өөртөө хүлээсэн үүрэг. Тэр үүргийнхээ дагуу бодьсадва нь зам мөрийн багш мөн. Бурхан болж гэгээрсэн Шакьямуни өөрөө ч сургаал номлолоо хүмүүст түгээсэн учраас нэг талаар “Гэгээрсэн (Бурхан) багш”, нөгөө талаар “бодьсадва” гэгддэг.

Тийм учраас богд Зонхава нийт төрөлхтний өмнө бурхан болж гэгээрэх зорилгыг тавихдаа түүнд хүрэхэд “тойны шүтээн дээд” хэмээн лам санваартан болох явдлыг эрхэмд үзсэн нь гэгээрч, бусдыг энэ замаар хөтлөх бурханы шашны үзэл санаанаас урган гарсан номлол юм. Бодьсадвагийн явдал зургаан барамидын эхний барамид болох өглөгийн дотроос номын өглөгийг дээдэд үздэгийг ч энэ үзэл санаатай холбоотой гэмээр.

Зонхавагийн онолын хувьд үндэслэсэн багшийг шүтэх ёсыг номын өглөгийг үйлдэх, бусдыг бурханы заасан зам мөрөөр хөтлөх бодьсадвагийн тухай сургаалаас төрсөн гэж үзэх гол үндэслэл энэ юм.

Би үгүйн хоосон чанарын үзэл санаа

Бурханы шашинтны бясалгалын нэг гол зорилго бол хоосон чанарыг онохуй юм. Би үгүйн хоосон чанарын энэхүү үзэл санаа харилцан хамааралтай орчлонд би хэмээх “орчлонгийн үндэс” болсон өөрийгөө хичээх үзлийг дарж, зохицон амьдрах чадварыг төлөвшүүлэхэд зориулагдаж байсан гэж үзэж болох байна.

Мөнх бус, байнга хувиран өөрчлөгдөх ертөнцөд хэтэрхий шунан тэмүүлж, өөртөө болон өрөөл бусдад зовлон хураах явдлаас татгалзаж, би хэмээн тачаах өөрийн болон бусдын сэтгэлийг ухамсраар ойлгон дарахад чиглэсэн энэхүү үзэл санааг хамтач үзэл санаа хэмээн тодорхойлж болох юм.

Нийгмийн философийн хувьд эл үзэл сайн талаас нь ярьвал би хэмээх үзлээ дарж, хамтач үзлийг төлөвшүүлэх, нийгмийг нэгдмэл бүхэл болгон нягтруулахад, муу талаас нь ярьвал аливаад “зохицох”, ноёрхогч үзэлд найр тавьж сургахад чиглэгдэж, эзэн харьяатын феодализмын ёсоор би үгүй болтлоо зүтгэх, өмчлүүлж ашиглуулах ёсны тулгуур үндэс болж байсан гэж үзэж болох юм.

Гаадамбын үзэл санаанаас эх авсан гэлүгва чиглэлд би үгүйн хоосон чанарын үзэл санаа чухал байр суурь эзэлдэг нь санамсаргүй бус мэт. Энэ үзэл санаа тухайн үеийн Төвдийн

нийгмийн нөхцөлд тохирч, тогтсон үзэл баримтлал болох гэлүгва ёсны "хамтач ёс суртахууны" тулгуур үндэс болжээ.

Багшийг шүтэх ёс ба теократи засаглал

"Бодь мөрийн зэрэгт" тавигдсан нэг зам мөрийн тухай сургаал нийгмийн нийт гишүүдийг бурханы шашны үзэл санаагаар нэгтгэх зорилготой байв. Энэ үзэл санааг хэрэгжүүлэх гол механизм нь теократи засаглал болжээ.

Тэрхүү теократи засаглалын онолын үндэс нь багшийг шүтэх ёс ба төрийн зохион байгуулалтын үндэс нь сүм хийдийн зохион байгуулалт болсон байна.

Теократи засаглалын онолын үндэс болсон багшийг шүтэх ёсны тухайд бол, Буддын шашинд энэ сургаалыг анх Будда (Бурхан багш) номлосон билээ. Харин богд Зонхавагийн сургаалд багшийг "бурхан мэт" шүтэхийг номлож, бурханы шашны зам мөрөөр хөтлөгч өөр өөрийн багшийг ийнхүү шүтэхийг бурхан болж гэгээрэх тулгуур үндэс болгожээ. /40/ Энэ сургаал хувь хүнд байдаг эрхэмлэлийг илэрхийлсэн боловч практик амьдрал дээр феодализмын эзэн харьяатын ёсны үзэл сурталжсан хэлбэр болж хэрэгжсэн байна.

Феодализмын онцлог гэгддэг шат дараалсан зэрэглэл бүхий эзэн харьяатын ёс "оюуны зэрэглэлийн" хэлбэрээр илэрч байсныг ийнхүү нэрлэж болмоор байгаа юм. Феодализм хөгжих явцад энэ нь оюуны хөдөлмөрийг үнэлэх болсныг гэрчлэх шинэ үзэгдэл байлаа. Багшийг шүтэх ёс нь цэрэг зэвсгийн хүчинд тулгуурладаг феодализм тогтох үетэй харьцуулахад оюун санааны "зэвсгийг" өндөрт тавих болсноороо ялгаатай байв.

Багшийг шүтэх ёс нь багш, шавийн ёс гэх зэрэг нийгмийн харилцааны олон талыг хамарч байв. Үүнээс гадна багшийг шүтэх ёсны хүрээнд үзэл санааны ялгарал, төрөл бүрийн бүлэглэлийн асуудал хамрагдаж байсан. Мөн багшийг шүтэх ёсны тухай сургаалд бурханы шашны үзэл санаанд тэрсэлсэн өөр үзэл санаанаас хатуу хамгаалалттай байх зарчим тусгалаа олсон байна. Энэ нь нийгмийг үзэл санааны итгэлээр нэгтгэн бэхжүүлэх зорилгыг агуулж байв. Гэхдээ нийгмийн сонголтыг бурхантны үзэл санаагаар хязгаарласан утгаараа энэ сургаал, хаалттай нийгмийн онолын сургаал болсон байна. Үзэл суртлын төвлөрлийг илэрхийлсэн энэ зарчим нэлээд хэмжээнд Төвдийн ээдрээтэй гадаад нөхцөлтэй холбоотой байжээ.

Бүхэлд нь авч үзвэл, хэрэв цэрэг феодалын улсад эдийн засгийн болоод улс төрийн эрх мэдэл нэгдмэл байхын сацуугаар харьяат нь эзэндээ юуны өмнө биеэр зүтгэдэг бол хөгжингүй феодализмын үе шатнаа эн тэргүүнд үзэл санаагаар үнэнч байж зүтгэх үзэл санааны харьяалал тогтсон байна. Харин төвлөн удирдах ёс нь эхний тохиолдолд цэрэг зэвсгийн хүчинд тулгуурладаг бол хоёрдахь тохиолдолд үзэл суртлын хүчинд тулгуурлах болжээ.

Теократи засаглалын онолын үндэс болсон багшийг шүтэх ёс нь бурханы шашны үзэл санаанд үнэнч байхын сацуу бурханы шашны зам мөрөөр хөтлөгч өөр өөрийн багшийг бурхан мэт шүтэн дагахыг эрхэм болгосноороо "намч" зохион байгуулалтын тулгуур үндэс болсон байна.

Ерөөс намын тухай ойлголт анх шашнуудын хүрээнд үүсч, зохион байгуулалтын арга хэлбэр нь ч шашны бүлэглэлүүдийн дотор төлөвшсөн гэж үзэж болох юм. Ашиг сонирхлоороо нэгдэх явдал дэлхийн шашнууд үүсэхээс өмнө байсан. Гэхдээ үзэл санаагаар нэгдэн, тодорхой дүрэм журмын дагуу үйл ажиллагаа явуулах явдал анх шашнуудын хүрээнд бий болсон билээ.

Католик шашинтнуудын дотор үүссэн орденуудыг угтаа намын нэр гэж үзэж болно. Буддын шашны хувьд, үзэл санаагаар нэгдсэн хүмүүсийн анхны байгууллага бол хуврагийн нийгэмлэгүүд бөгөөд ийм тогтолцоо хавьгүй эрт үүсжээ.

Харин дорно дахины Зонхавагийн үндэслэсэн гэлүгва ёсонд нэг хүний үзэл санааг илүүтэй дагах намч зарчим багшийг шүтэх ёсны тухай сургаалд нь тодорхой үндэслэлээ олж сүм хийдийн зохион байгуулалтаар практикт хэрэгжсэн юм.

Сүм хийдийн энэхүү зохион байгуулалт Зонхавагийн өөрийн байгуулсан эх хийд ба шавь нарынх нь байгуулсан гэлүгва ёсны харьяалал бүхий хөвгүүн хийдүүд байгуулагдсан түүхээс харагддаг. Зонхавааас хойш Брэйбүн (Drepung) хийдийн тэргүүн нар шашин төрийг хослон барих болсон нь энэ зохион байгуулалтын үр дүн байсан юм.

Зонхавааас өмнө төрийн эрхэнд байсан Сажавагийн ёсонд хийдийн тэргүүний залгамжлал кон овгийнхны дотор явагддаг байсан бол гэлүгва ёсонд үзэл санааны шалгуураар явагдах болжээ. Энэ нь уг чиглэлийнхэн засгийн эрхэнд гарах нэг нөхцөл болсон байна. Овог төрлийн зохион байгуулалттай харьцуулахад үзэл санааны буюу намын энэхүү зохион байгуулалт нийгмийн гишүүд засаглалд илүүтэй оролцох бололцоо олгож байснаараа гэлүгва ёсыг Төвдийн нийгмийн тэргүүлэгч чиглэл болгож чадсан болов уу.

Дүгнэлт

Нэг. Төвдийн феодалын бутрал, үүний илрэл болж байсан бурханы шашны олон урсгал чиглэлийн тэмцлийг эцэс болгоход чиглэгдсэн Зонхавагийн "шинэчлэл" буддын шашны өвөрмөц онцлог бүхий гэлүгва чиглэлийг төрүүлсэн төдийгүй түүнийг нийгмийн, "төрийн философи" болгох тулгуур болжээ.

Дэлхийн томоохон шашнууд нийт хүн төрөлхтөнд хандахдаа нийтэд хамаарах "үнэмлэхүй үнэний" асуудлыг тавьж ирсэн бөгөөд ингэхдээ чухамхүү өөрийн сургаалыг "үнэмлэхүй үнэн" гэж үзэж ирсэн. "Үнэмлэхүй үнэнийг" агуулсан шашны сургаал номлол нийгмийн практикт нэвтрэх

явцдаа теократи засаглалд хүргэж байсан нь дэлхийн гурван том шашны аль алины жишээн дээр харагддаг. "Үзэл суртлын хаанчлал" гэж нэрлэж болох засаглалын энэ хэлбэрийг эзэн харьяатын ёс бүхий феодалын нийгмийн бүтээгдэхүүн гэж үзэж болох юм.

Христос шашин дахь теократи засаглалын сонгодог хэлбэр нь католик шашин сүм хийдийн тэргүүн паап лам нараас Ватикан улсын төрийг хослон барьдаг явдал юм. Лалын шашны ертөнцөд мөн л теократи засаглал тогтож байсны нэг жишээ бол Арабын халифат болно.

Буддын шашны хувьд гэвэл, энэ шашны үзэл санаа цорын ганц үзэл суртал болтлоо төлөвшиж, "үзэл суртлын засаглал" тогтох онолын үндсийг тавьсан хүн бол богд лам Зонхава мөн. Буддын шашны ертөнцөд теократи засаглал чухамхүү гэлүгва ёсны ноёрхлын үед гарч ирсэн нь санамсаргүй хэрэг биш бөгөөд энэ чиглэлийг үндэслэгчийн үзэл баримтлалд теократи засаглал онолын үндэслэлээ олсон байна.

Түүний "Бодь мөрийн зэрэг" зохиол дахь: хамаг шашныг (бурханы) харшуулалгүй онох, их, бага, очирт хөлгөнийг нэг зам мөрийн үе гишүүн болгож, энэ замаар дэс дараалан хөтлөх багшийг шүтэх ёсыг онолын хувьд үндэслэсэн үзэл санаа нь Төвдийн цорын ганц үзэл суртал болтлоо хөгжиж, түүний гэлүгва ёс Төвдийн бусад бүх чиглэлийг "хураан", шар малгайтны шашны тэргүүн Далай лам нараас шашин, төрийг хослон барьсан теократи засаглал тогтох онолын үндэс болжээ. Шарын шашин дэлгэрэхийн хамтаар энэ ёс Монголд ч хэрэгжих болсон билээ.

Багшийг шүтэх ёс нь багш, шавийн барилдлагаар зохион байгуулагдаж, бурхан болж гэгээрэгсдийн үзэл санааг ягштал уламжлуулах хэрэгсэл болсон хувилгаадын тухай номлолд тулгуур болжээ.

Ийнхүү, хаант засаг бүхий феодалын нийгмийн үе дэх шашны хязгааргүй ноёрхол гадаад, дотоод хүчин зүйлийн "тохироогоор" теократи засаглалд хүргэж байсны нэг жишээ бол шарын шашин юм.

Хоёр. Зонхавагийн номлосон нийгмийн философийг их хөлгөний философийн зүй ёсны логик үр дагавар гэж үзэх үндэстэй.

Буддын философид зовлонгоос ангижрах арга зам нь урин, мунхаг, тачаангуйгаас чөлөөлөгдөх явдал хэмээн үзэж, үнэмлэхүй үнэнд хүрэх арга замыг авралын зам мөрийн тухай сургаалаараа номлодог. Гэвч хэрэв анхан үеийн буддизм буюу Бага хөлгөний философид юуны өмнө хувь хүнийг энэ зам мөрөөр чиглүүлэхэд голлон анхаарч, нийт хүн гэгээрэх бололцоогүй гэж үзэж байсан бол цаг хугацааны хувьд түүнээс хойш үүссэн Их хөлгөний философид нийт хүн аврагдах бололцоотой, гагцхүү энэ бололцоо хэчнээн төрөл дамжин биелэгдэх нь харилцан адилгүй байна гэсэн санаа гарч

биелэл гэж үзэж болох юм. Ийнхүү өөр өөрийн багшийг бурхан мэт шүтэхийг номлосон богд Зонхавагийн сургаал феодализмын эзэн харьяатын ёсны үзэл сурталжсан хэлбэр болж хэрэгжсэн байна.

“Бодь мөрийн зэрэгт” тусгалаа олсон - багшийг тойрч үзэл санаагаар нэгдэх намч зарчим нь богд Зонхавагийн хэрэгжүүлсэн сүм хийдийн зохион байгуулалтаар практикт төлөвшин хэрэгжиж, (гэлүгва ёсны тэргүүн нараас) шашин, төрийг хослон барих теократи засаглалын үлгэр загвар болжээ. Гэлүгва ёсонд хийдийн тэргүүний залгамжлал үзэл санааны шалгуураар явагдах болсон нь уг чиглэлийнхэн засгийн эрхэнд гарах нэг чухал нөхцөл болсон байна.

Багшийг шүтэх ёсонд тусгалаа олсон бурханы шашинд тэрсэлсэн өөр үзэл санаанаас хатуу хамгаалалттай байх зарчим нийгмийн сонголтыг бурхантны үзэл санаагаар хязгарласан нь буддын ертөнц дэх авторитаризмын илрэл, хаалттай нийгмийн онолын зарчим болжээ. Үзэл суртлын төвлөрлийг илэрхийлсэн “Тэрс үзлийг үл шүтэх” тухай энэ зарчим Төвдийн ээдрээтэй гадаад нөхцөлд тухайн үеийн Төвдийн үндэстний тусгаар тогтнолыг хамгаалах учир холбогдолтой байсан байж болох хэдий ч Төвдийг дэлхийн нийтийн хөгжил дэвшлээс хөндий “хаалттай” нийгэм болоход ч хүргэсэн байж бас болох юм.

Нөгөө талаар, энэ үзэл санааг удирдлага болговол шарын шашныг “дэлхийн шашины” нэг болох буддын шашны “Хойд Азийн хувилбар” гэж үздэг явдлыг ор үндэсгүй зүйл гэж үзэж бас ч болохгүй болов уу.

Тухайн үеийн нийгмийн эрэлт хэрэгцээний тусгал болон шинэ урсгал чиглэлүүд үүсч, амьдралын философид нь өөрчлөлт орж байсан дэлхийн бусад шашнуудын хөгжлийн онцлог буддын шашны хувьд ч ийнхүү илрэлээ олж, шарын шашин нь Төвдийн ард түмний нэгдэл нягтралын бэлгэ тэмдэг болж, “үндэстний” буюу бүс нутгийн шашин болтлоо хөгжжээ.

Гэлүгва чиглэлийг үндэслэсэн төдийгүй Төвдийн албан ёсны үзэл суртал болтлоо төлөвшсөн энэ чиглэлийн нийгмийн философийн үзэл санааг оюолын хувьд боловсруулж, зохион байгуулалтын олон талын арга хэмжээ авч практикт хэрэгжүүлсэн богд лам Зонхаваг шашны “шинэтгэгч” төдийгүй, буддын ёсны нийгмийн байгуулал, буддын ертөнц дэх авторитаризмыг үндэслэгч гэж үзэж болох юм.

The Socio-Philosophical ideas in the “Grades on the Path to Bodhi” by Tsonkapa

Summary: Gelukpa is buddhist direction which was widely spreaded not only in Tibet, but also in Mongolia and has long tradition to exert influence on the whole social life of these countries. Theoretical basis of this direction is represented by its founder's work “Grades on the

Path to Bodhi". The author O.Chimeg considered contents of this work in socio-philosophical aspect.

As the socio-philosophical basis of Gelukpa the author considers the doctrine about three categories of people and Tsonkapa's teaching about yoga practice as one of the main criterias to distinguish them and interprets it as "meditation process inherent in all people".

Last part of the work is devoted to worship of one's teacher which is regarded as one of the main principles of gelukpa's social philosophy and ideological basis of theocratic form of government

The author considers that worship of one's teacher theoretically substantiated by Tsonkapa, which makes disciple's duty to attach himself to his teacher's views and devote to him, was an example of party principle and had been practically embodied in organization structure of gelukpian monasteries.

Ном зүй:

А) Эх сурвалжууд

1. а) Лувсандагва (Зонхава). Гурван төрөлхтний анхааран авах бодь мөрийн зэрэг оршвой. Бээжин бар (Төвд хэлээр). Цаасны хэмжээ 49.5х9.5, барын хэмжээ 27х6, мөрийн тоо 5, хуудасны тоо 223 (Эшлэлийг энэ номоор заав).

б) Лувсандагва (Зонхава), Бага бодь мөрийн зэрэг оршив. Төвдийн Молом равжамба хийгээд Монголын гүүш Наганзуна Жүдва аягха тэхимлиг нарын монгол орчуулга.

2. Лувсандагва (Зонхава). Бодь мөрийн зэргийн анхааран авахуй товч хураангуй. Төвд бар.

3. Г.Ц.Цыбиков. Лам-рим чэн-по. (Степени пути к блаженству) Сочинение Цзонкапы в монгольском и русском переводах. Том 1. Низшая степень общего пути. Выпуск II. Русский перевод с предисловием и примечаниями. Владивосток, 1913.

4. Чже Цонкапа. Большое руководство к этапам пути пробуждения. Перевод с тибетского языка А.Кугявичуса. т 1. Санкт-Петербург. 1994.

Б) Судалгааны ном зохиол

5. Ш.Бира. Монгольская тибетоязычная историческая литература (XVII-XIX), УБ., 1960.

6. М.Г.Брянский. О европейских переводах трактата Васубанду "Опровержение понятия личности" – Исследования по истории и филологии Центральной Азии. Улан-Удэ. 1976

7. Н.Д.Болсохоева. Сакья-пандита и его изречения. - Исследования по истории и филологии Центральной Азии. Улан-Удэ, 1976.

8. Б.Я.Владимирцов. Буддизм в Тибете и Монголии. Лекция, читанная 31 сентября 1919 года. Петербург, 1919.

9. Д.Дагвадорж. Гурван билигтний тухай хүүрнэхүй. Төгс цогт Атиша Бодь мөрийн зул оршив. (Монгол эх). - Бодрол, бясалгал. 1993. №1-2.

10. Дагвадорж Дондогийн. Критический анализ ламаистской концепции человека. На материалах средневековых тибетских и монгольских источников. 09.00.06.-Диссертация д/ра филос.наук М., 1988.-364 л (МГУ им. М.В.Ломоносова).

11. Д.Дагвадорж. Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлиг. УБ., 1994.

12. Дагвадорж Д. Хүний тухай шарын шашны үзэл, УБ., 1983.
13. III Далай лам Содномжамц. Бодь мөрийн зэргийн хөтөлбөр тунгаамал алтан хэмээгч оршвой. УБ., 2000.
14. Д.Дашбадрах. Монгол – Түдэвийн улс төр, шашны харил-цааны түүх (ХҮI-ХҮIII зууны эхэн), УБ., 1998.
15. Д.Б.Дашиев. Некоторые социально-психологические аспекты культа наставника (по тибетским источникам). - Психологические аспекты буддизма. Новосибирск, 1986.
16. Д.Б.Дашиев. Традиции "Нитишастр" в тибетской афористической литературе ХҮIII-XIX вв. - Буддизм и литературно-художественное творчество народов Центральной Азии, Новосибирск, 1985.
17. Ж.Д.Доржиев, А.М.Кондратов. Гомбожав Цыбиков. Иркутск, 1990.
18. Г.Н.Крапивина. Традиция в школе сакьяпа (по материалам "Дубмта-шэлчжи-мэлон"). - Источниковедение и историография истории буддизма. Новосибирск, 1986.
19. Краткое жизнеописание Чже Цонкапы (1357-1410). Чже Цонкапа. Большое руководство к этапам. Пути Пробуждения Перевод с тибетского языка А.Кугявичуса. т 1. Предисловие. Санкт-Петербург, 1994.
20. А.Е.Кулаков. Религии мира. М., 1996
21. Ламаизм в Бурятии XVII - начала XX в.
22. Г.Лувсанцэрэн. Нагаржунагийн философийн үзэл, УБ., 1981.
23. Ф.Ницше. Сочинения в 2-х томах. М., 1990.
24. С.Пүрэвжав. История ламаистской церкви в Монголии в конце XVI - начале XX вв. Автореферат диссертации на соискание ученой степени доктора исторических наук.
25. С.Пүрэвжав. Монгол дахь шарын шашны хураангуй түүх. УБ., 1978.
26. Ю.Н.Рерих. Тибетско-русско-английский словарь с санскритскими параллелями. Вып.1-10. М., 1983-1987.
27. Л.С.Савицкий. Предисловие к изданию "Песен, приятных для слуха" Цаньян Джамцо, М., 1983.
28. Советский энциклопедический словарь. М., 1986.
29. Сумадишила (Цахар гэвш Лувсанчүлтэм). Хамгийг айлдагч их богд Зонхавагийн гэгээний намтар мэдэхүйеэ хялбар болгон өгүүлсэн Сайн амгалан бүхэн гарахын орон. (Монгол хэлээр)
30. М.С.Тартаковский. На весах столетий.- Проблемы Дальнего Востока. 1989. №6.
31. Туган Лувсанчойжиням. Тогтсон таалал бүхний уг хийгээд таалах ёсыг номлосон сайн номлол Болорын толиос (12 дэвтэр). Номч төвдөч Шагжийн орчуулга. Гар бичмэл.
32. Г.Ц.Цыбиков. Избранные произведения в двух томах. Новосибирск, 1981.
33. О.Чимэг Багшийг шүтэх ёсны онолын утга агуулга. Дорно, өрнө, 1991, дугаар 4.
34. О.Чимэг. Зонхавагийн "Бодь мөрийн зэрэг" дэх нийгмийн харилцан үйлчлэлийн зарчмууд. – "Гүн ухаан, нийгмийн сэтгэлгээ", 1992, дугаар 1.
35. О.Чимэг. Зонхавагийн "шинэчлэл" ба теократи засаглал. – "Эрх чөлөө ба философи", дугаар 7, УБ., 2000.
36. Бодонгууд О.Чимэг. Зонхавагийн "Бодь мөрийн зэрэг" дэх нийгмийн философийн үзэл санаа. Философийн ухааны докторын (Ph.D) зэрэг горилсон бүтээл. УБ., 2001.
37. Herbert V.Guenther. Introduction to SGam Po Pa' S Jewel Ornament of Liberation. Dam chos yid, bzin gyi nor bu tharpa rim po che'i rgyan zes bya ba theg pa chen po'i lam rim gyi bsad pa. London, 1959.
38. E.Obermiller. The doctrine of Prajna-paramita as exposed in the Abhisamayalamkara of Maitreya, Leningrad, 1934